



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 01/2024

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, иргэдийн санал санаачилгыг сонсож, төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагаанд тусгах зорилгоор сумдад ажиллахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Сумдад ажиллахад шаардагдах зардал 31.500.000 (гучин нэгэн сая таван зуун мянга) төгрөгийг батлагдсан төсвөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, уулзалт зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ